



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 27 өдөр

Дугаар A/52

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зохицуулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. "Монгол түмний мэнд" нэвтрүүлэгт оролцоход шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.
2. Нэвтрүүлэгт оролцоход шаардагдах 870,100 (найман зуун далан мянга нэг зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батзоригт зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны
01 дугаар сарын 17 ны өдрийн 115 дугаар
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Дүн
1	Бренд бүтээгдэхүүн	ширхэг	40	13,500	533,500
2	Хэрэглээний материал	ширхэг	10	4,950	49,500
3	Хүнсний материал	кг	29	9000	287,100
	Нийт дүн		50		870,100

__оОо__